

ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГЫН УДИРДЛАГА

О.Отгонтуяа - Дотоод хэргийн их сургуулийн

Эрх зүй, нийгмийн ухааны сургуулийн

Хувийн эрх зүйн тэнхимийн

ахлах багш, цагдаагийн хошууч

ГЭР БҮЛИЙН ДУНДЫН ЭД ХӨРӨНГИЙН ЭРХ ЗҮЙН АГУУЛГА

Хураангуй. Гэр бүл нь нийгмийн анхдагч нэгж, аливаа улс орны оршин тогтнох язгаар үндэс болдог. Гэр бүл, гэрлэлтийн харилцаанд гэр бүлийн гишүүд ямар эрх хэмжээтэй оролцох, өмчийн асуудлыг хэрхэн нямъяалж ойлгож байсан талаар сэтгэгчдийн сэтгэлгээ, үзэл баримтлал, шинжлэх ухааны ойлголтуудад судалгаа хийлээ.

Summary. The family is the basic unit of society and the foundation of any nation. My research is about whole of survey of thinkers' thinking, concepts, and scientific understandings on the rights of family members to participate in family and marriage relationships and how they formulated and understood property issues.

Түлхүүр үг. гэр бүл, гэр бүлийн гишүүн, гэр бүлийн хөрөнгө, өмч

Keywords. family, family member, family property, property

Оршил

Гэр бүлийн дундын эд хөрөнгийн эрх зүйн агуулгыг тодорхойлохдоо гэр бүлийн үүсэл хөгжил, гэр бүл, гэрлэлт, өмчийн талаарх үзэл баримтлалыг тоймлон судаллаа. Учир нь гэр бүлийн дундын эд хөрөнгийн ойлголтыг нэг талаас гэр бүлийн эрх зүйгээр, нөгөө талаас иргэний эрх зүйгээр зохицуулдаг.

Дундын эд хөрөнгийг бүрдүүлэгч өмчийн талаар Монгол улсын Иргэний хуульд тусгайлан нэршсэн ойлголт байхгүй харин өмчийн төрөл, хэлбэрийг талаар авч үзсэн байдаг. Тиймээс уг сэдвийн хүрээнд гэр бүлийн дундын эд хөрөнгийн үндсэн ойлголтод хамаарах гэр бүл, гэрлэлт, өмчийн ойлголтыг эрдэмтэд, нийгмийн байгууллын үед, шинжлэх ухааны судлагдахуунд хэрхэн томъёолж тодорхой хүрээнд нэгтгэн дүгнэлээ.

Үндсэн хэсэг

Гэр бүл нь нийгмийн шинжлэх ухаануудын судалгааны объект, хүн төрөлхтний нийгмийн анхны цогц ойлголт бөгөөд нийгмийг бүрдүүлэгч нэгж билээ¹. Гэр бүлийн үүсэл, хөгжил нь түүхэн үзэгдэл бөгөөд одоогоос 40000-4000 жилийн өмнө хүмүүс амьдарч байсан судалгаа байдаг².

¹ Дондог.Ч, Гэр бүл, соёл, иргэншил, Уб., 1977, 4 дэх тал

² Намжил.Т, Монгол гэр бүл судлал 1, Уб., 2006, 9-17 дахь тал

Төв Азийн эртний соёл иргэншлийн нэгэн голомт болох одоогийн МУ-ын нутаг нь эрт цагийн хүний бүтээсэн эд өлгийн дурсгалаар баян эх орон. Тухайн үед хүн амьдарч, хамтын хөдөлмөр эрхэлж байсан талаар түүх, соёлын олдвороос дурдвал, Дорнод аймгийн Тамсагбулагаас шинэ чулуун зэвсгийн үеийн эрүкэ сууц (МЭӨ 7000-4000 жил), Сэлэнгэ мөрөнд цутгадаг Буриад Монголын Үдэ голын хаднаас гэр бүлийн хөрөг зураг, Увс аймгийн Чандмань уулнаас олдсон булш, Говь-Алтай аймгийн Цагаан голын хаднаас гэр, сууны хөрөг зураг, Сүхбаатар аймгийн Дарьганга сумын нутагт гэр бүлийн чулуун хөрөг зураг зэрэг олдворыг нэрлэж болно¹.

Гэр бүлийн дундын эд хөрөнгийн эрх зүйн агуулгыг тодорхойлохдоо гэр бүлийн тухай, гэрлэлтийн тухай, өмчийн тухай түүхэн ойлголтын хүрээнд тодорхойлон авч үзлээ.

1. Гэр бүлийн ойлголт: Гэр бүл гэх ойлголтыг түүхийн төдийгүй философи, сэтгэл судлал, социологи, эрх зүй зэрэг нийгмийн шинжлэх ухааны олон салбарт тодорхойлон тайлбарлаж ирсэн юм. Тэдгээрийг сэтгэгчдийн үзэл баримтлал, нийгмийн байгуулал, шинжлэх ухааны салбаруудад хэрхэн тусгасан талаар дараах байдлаар авч үзлээ.

Ромын эрх зүйд: Өрх гэр, гэр бүл гэсэн ойлголт анх Ромын эрх зүйд бий болсон, гэр бүл нь нэгэн өрхийн тэргүүний эрхшээлд буй хүмүүсийн нэгдэл, өрх гэр ба эрэгтэй, эмэгтэй хүний удам нь гэр бүлийн харилцаа юм² гэж үзсэн. Гэр бүл нь өрхийн тэргүүний засаглал дор байгаа хувь этгээд, эд хөрөнгийн нэгдэл³ гэж үзээд гэр бүлийг

1. Агнатууд буюу ясан төрлийн гэр бүл нь эцэг талаасаа нэг гаралтай гишүүд, мөн гэр бүл болох, хүүхэд үрчлэн авснаар бий болдог.

2. Когнатууд буюу цусан төрлийн гэр бүл нь өрхийн тэргүүний засаглалд байхгүй ч түүнтэй цусан төрлийн холбоотой эрэгтэй, эмэгтэйн хамаатнуудыг хамаарна.

Эрдэмтэд: И.Кант, Фихте нар гэр бүл нь нийгмийн хөгжлийн анхдагч бичил орчин бөгөөд хууль ёсоор харилцах хүйсийн харилцаа буюу хууль ёсны гэрээ юм,

Ф.Энгельс гэр бүл нь хамтын нөхөн үйлдвэрлэл явуулах зориулалттай эхнэр, нөхрийн хоорондын харилцаа,

Г.В.Гегель гэр бүл нь байгалийн болон ёс суртахууны холбоо, энэ холбоо өмчтэй холбоотой үүснэ⁴,

¹ Монголын угсаатны зүй, I, II, III боть, Уб., 1987, 1992

² Одонхүү.Т, Ромын эрх зүй, Уб., 1999, 87 дахь тал

³ Минжүүрдорж.Б, Ромын эрх зүй, Уб., 2004, 70 дахь тал

⁴ Тунгалаг.Д, Гэр бүлийн ёс суртахуун, Уб., 2000, 11 дэх тал

Т.Афанасьев гэр бүл нь цусан төрлийн ба эдийн засгийн байдлаар бус оюун санааны нийтлэгээр холбогдсон хүмүүс,

А.Г.Харчаев хүн амын биеийн болон оюун санааны хэрэгцээ, нийгмийн ишардлагаар нөхцөлдсөн гэрлэлт, ураг төрлийн буюу эхнэр, нөхөр, үр хүүхдийн харилцаа, түүнчлэн ахуйн, ёс суртахууны хариуцлагаар холбогдсон гишүүд бүхий нийгмийн бага бүлэг¹,

Г.М.Нечаева гэрлэлт, ураг төрлийн үндсэн дээр аж ахуйн нийтлэг ашиг сонирхолтой, ур удмаа төрүүлж, хүмүүжүүлдэг, харилцан эрх, үүрэгтэй хүмүүсийн нэгдэл,

С.А.Муратова гэрлэлт, ураг төрөл, үрчлэлт, гэр бүлд хүүхдийг хүмүүжүүлэх явцад үүссэн эрх, үүргээр холбогдсон хамтран амьдарч байгаа хүмүүсийн нэгдэл,

Е.М.Ворожейкин хүүхэд төрүүлэх, хүмүүжүүлэх, аж ахуйгаа хамтран хөтлөх, оюуны болон эр, эмийн харилцаа тогтоох, эд хөрөнгийн эрх, үүрэг эдлэх зорилгыг хүлээсэн гэр бүл, ураг төрөл, хүүхэд үрчлэх ба хуулийн бусад үндэслэлээр үүсэн бий болсон хүмүүсийн амьдрал,

К.Маркс, Ф.Энгельс нар гэр бүл гэдэг нь эхнэр болон нөхрийн хоорондын хийгээд эцэг, эх, хүүхдийн хоорондын харилцаа юм^{1 2} гэж тодорхойлсон байна.

Германы сонгодог философиос хойш гэрлэлт, гэр бүл нь биологийн ухагдахуун³, нийгмийн ухагдахуун⁴ гэж үзэж байсан.

Морган гэр бүлийг түүхэн ухагдагдахуун болдгийг анх удаа дэвшүүлэн, гэр бүлийн тухай шинжлэх ухааныг бий болгожээ⁵. Тэрээр гэр бүлийг дараах дөрвөн хэлбэрт хуваасан байдаг.

1. Махан төрлийн өрх гэр (эцэг-охин, эх-хүүгийн холбоо)
2. Пулалуа өрх гэр (ах, эгч, дүүсийн холбоо)
3. Хосолсон гэр бүл (бүлгээрээ гэр бүл болох буюу нэг хүний нэрийн доор олон эхнэр авч эхнэрүүдээ эзэмших холбоо)
4. Моногам гэр бүл (эрэгтэй, эмэгтэй хоёрын холбоо буюу гэрлэн суугчдын аль нэгний саналаар биш зөвхөн эрэгтэй нь гэр бүлээ цуцалж, эхнэрээ хаяж болох холбоо)

Нийгмийн байгууллын үед: Ф.Энгельс Нийгмийн хөгжлийн тухай онолд тулгуурлан гэрлэлтийн гурван хэлбэр байна гэж дараах байдлаар тайлбарласан. Үүнд:

1. зэрлэг үед бүлгээрээ гэр бүл болох ёс,

¹ Антольская.М.В, Семейное право, 1996, 251 стр

² Бүрэнжаргал.Т, Гэр бүлийн социологи, Уб., 2008, 46 дахь тал

³ Фрейд “гэр бүл бол бэлгийн үйлдэл”

⁴ Маркс.К, Энгельс.Ф, Түүвэр зохиол, 3 боть /Ф.Энгельс Өрх гэр, хувийн өмч, төрийн үүсэл/, Уб., 1971, 192 дахьтал

⁵ Бүрэнжаргал.Т, Гэр бүлийн социологи, Уб., 2008, 36 дахь тал

2. бүдүүлэг үед хосолсон гэр бүл,

3. соёлт үед эр, эмийн үнэнч байдлыг зөрчсөн моногам хэлбэртэй байсан ба бүдүүлэг үеийн дээд шатанд хосолмол гэр бүл ба моногамт ёсны хоорондуур эрэгтэйчүүд, боол эмэгтэйчүүдийг ноёрхох ноёрхол, олон эхнэртэй байх ёс хавчуулагдан иржээ¹.

Ф.Энгельс моногам гэр бүлийн үндсэн шинжийг “нэгэн эцгийн хэд хэдэн үе удмыг эхнэр, хүүхэдтэй нь хамтарч, тэгэхдээ бүгдээр нэгэн гэртн суудаг, тариан талбайгаа хамтран боловсруулж, нишпийн дундын нөөцөөр хооллож, хувцасладаг... байсанд оршино”² гэж тодорхойлжээ.

Нийгмийн байгууллын хэлбэрийг бүрдүүлэгч социалист гэр бүл нь тэгш эрх, хайр сэтгэл, энэрэнгүй хүнлэг ёсны үндсэн дээр үүсч, эмэгтэй хүн гэр бүлийн бүрэн эрхт гишүүн байдаг³, хөдөлмөрийн ангийн гэр бүл нь хүний материллаг хэрэгцээг хэлбэржүүлэн тогтоох, бүрдүүлэх, ахуйн тодорхой дадал заншлыг нэвтрүүлэх үүрэг гүйцэтгэдэг эцэг, эх, хүүхэд, садан төрлийн харилцаа⁴ гэж үзэж байжээ.

Шинжлэх ухааны судлагдахуунд: Социологийн талаас нь хүмүүсийн холбоо бөгөөд уг холбооны үндэс нь гэрлэлт, төрөл садан, үрчлэлт⁵,

Сэтгэл зүйн талаас нь сэтгэл зүйч, гэр бүл судлаач А.А.Обозова эхнэр, нөхөр хоёрын сэтгэл зүйн дотоод мөн чанар, үнэлэмж⁶,

Хүн ам зүйчид орон сууц, төсөв зардал, садан төрлийн хэлхээ холбоогоор нэгдсэн нийгмийн жижиг бүлэг⁷ гэж тус тус тодорхойлон салбарт бүрт хөгжүүлж иржээ.

Хууль зүйн салбарт: Гэр бүл хэмээх ойлголтыг доктор, профессор Т.Мөнхжаргал “гэр бүл болох буюу гэрлэх гэдэг бол иргэн хүнд байгаль нийгмээс заяасан зайлшгүй эдлэх ёстой туйлын эрх юм”⁸,

Доктор Б.Улаанбаатар “гэрлэлтийн үр дүнд бий болсон, эд хөрөнгийн бус амины болон эд хөрөнгийн эрх, үүргээр холбогдсон хамтын амьдрал бүхий гэр бүлийн гишүүд”⁹,

Оросын судлаач Б.А.Ресянцева ‘Гэр бүл нь хууль зүйн утгаараа бол гэр бүл, ураг төрөл, үрчлэлт болон өөр ямар нэгэн хэлбэрээр хүүхдийг авч хүмүүжүүлэх ба ёс суртахууны зарчим дээр гэр бүлийн харилцааг хөгжүүлж

¹ Маркс.К, Энгельс.Ф, Түүвэр зохиол, 3 боть /Ф.Энгельс Өрх гэр, хувийн өмч, төрийн үүсэл/, Уб., 1971, 282, 283, 296 дахь тал

² Намжил.Т, Монгол гэр бүл судлал 1, Уб., 2006, 7 дахь тал

³ Чанцал.Д, Гэр бүл ба гэрийн эзэгтэй, Уб., 1990, 3 дахь тал

⁴ Дондог.Ч, Гэр бүл, соёл иргэншил, Уб., 1977, 4-5 дахь тал

⁵ Иванов.М.А., Гэрлэлт, гэр бүл, үр хүүхэд, Уб., 1985, 3 дахь хэсэг

⁶ Батцэнгэл.Г, Бандихүү.Б., Гэр бүлийн сэтгэл судлал, Уб., 2012, 8 дахь тал

⁷ Мөн тэнд, 10 дахь тал

⁸ Мөнхжаргал.Т, Гэр бүлийн эрх зүй, Уб., 2004, 52 тал

⁹ Улаанбаатар.Б, Иргэний эрх зүйн тайлбар толь. Уб., 2005, 93 тал

бэхжүүлэх зорилгоос урган гарсан эрх, үүрэгтэй холбоотой бүлэг хүмүүс юм”¹ гэж үзсэн байна.

Түүхэн үед гэр бүл, өрх гэр гэсэн ухагдахууныг хэрэглэж байсан бөгөөд гэр бүл түүхэн хөгжлийн явцад хөгжин өөрчлөгдөж байдаг эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн хоорондын харилцааны нийгмийн хэлбэр, өрх гэр бий болох үндсэн нэгж нь гэр бүл юм гэж дүгнэж болно. Мөн **Гэр бүл гэдэг нь гэрлэлт, үрчлэлтийн үр дүнд бий болсон эд хөрөнгийн бус болон эд хөрөнгийн эрх, үүргээр холбогдсон хамтын амьдрал бүхий нийгмийг бүрдүүлэгч гэр бүлийн гишүүдийг хэлнэ** гэж томъёоллоо.

2. Гэрлэлтийн ойлголт: Гэр бүл болох анхны нөхцөл нь гэрлэлт ба Ромын хуульчдын тодорхойлсноор **гэрлэлт нь эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн бүхий л амьдралын холбоо, бурхны болон хүнийн эрхийн нэгдэл, хамтран амьдрах зорилго бүхий эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн холбоо**²,

Ромын хуульч Модестина гэрлэлт нь **бурхны болон хүмүүний ёсоор холбогдсон эхнэр, нөхрийн бүхий л амьдралын нэгдэл, холбоо**³,

И.Кант гэрлэлт нь зөвхөн хүүхэд төрүүлэх, хүмүүжүүлэх ажлаар хязгаарлагдахгүй, өөр хүйсийн хүмүүс бие биеийн, хүйсийн шинжийг агуулсан насан турш эзэмдэхийн тулд нэгдэх явдал, өөрөөр хэлбэл хууль ёсоор харилцах хүйсийн харилцаа буюу хууль ёсны гэрээ⁴,

Ёс зүйн хүрээнд хайр сэтгэлээр нэгдсэн эрэгтэй, эмэгтэй хоёр хүний холбоо⁵ гэж үзэж байжээ.

Дээрхээс эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн хоорондын харилцааг хуульд заасан үндэслэл, журмын дагуу зохицуулсан, бие биедээ, үр хүүхэд, гэр бүлийн гишүүдэд хандах эрх, үүргийг тогтоож өгсөн нийгмийн онцгой бүрэлдэхүүн хэсгийг гэрлэлт гэнэ гэж томъёоллоо.

3. Өмчийн тухай ойлголт: Өмч гэсэн ойлголт нь эдийн засаг, улс төр, хууль зүйн судлагдахууны хувьд судлаачид өөр өөрийн үзлээр тайлбарлаж ирсэн ба тэдний заримыг авч үзвэл;

Хүн төрөлхтөн хөгжлийн эхэн үед буюу балар эртний хүй нэгдлийн үед оршин тогтнохын төлөө байгальтай хийх тэмцэлд ашиглаж байсан хөдөлмөрийн багаж зэвсэг, хэрэгслийг нийтээр өмчилж байсан бөгөөд энэ үед өмчийн нийгмийн бүдүүлэг хэлбэрээс өөр хэлбэр байх нь бүү хэл өмчийн тогтвортой объект болох зүйлээр тун ховор байлаа. Тэд ураг төрлийн хүй нэгдлийг аажмаар халж, хөдөөний хүй нэгдэл өмчийн нийгмийн бүдүүлэг хэлбэрээр хувийн өмчид шилжих болжээ.

¹ Сергеева.А.П, Толстой.Ю.К., Гражданское право, 1996, 428 стр

² Минжүүрдорж.Б, Ромын эрх зүй, Уб., 2004, 76 дахь тал

³ Сэлэнгэ.Х, Ромын эрх зүй, Уб., 1999, 144 дэх тал

⁴ Тунгалаг.Д, Гэр бүлийн ёс суртахуун, Уб., 2000, 8-9 дэх тал

⁵ Тунгалаг.Д, Гэр бүлийн ёс суртахуун, Уб., 2000, 19 дэх тал

Ромын хуульчид өмч гэх ойлголтыг эхэн үедээ эд юмс буюу эзэмшилд байгаа биет зүйлс гэж тайлбарлаж байсан бөгөөд түүнийг эзэн тэнгэрийн, хүний гэж ангилан авч үзэж байсан. Үүнээс хойш хувийн өмчтэй холбон тайлбарлаж өмч бол хөрөнгө бус чадвар, энэ нь хүний эрх зүйн байдлыг тодорхойлон өмчгүй хүн эрх чөлөөгүй байна гэж үзсэн.

Нийгмийн зохион байгуулалтын нэг хэлбэр бол хувийн өмч мөн. Өөрөөр хэлбэл хувийн өмч нь эд баялаг, хөрөнгө мөнгөтэй холбогддог ч хүний эрхэм чанрыг түүнээс дээгүүрт тавьж, хувь хүний эрх чөлөөний тулгуур нь юм гэдгийг сэтгэгчид байнга онцолсоор иржээ. Аристотель “хууль бүтээгчид хувийн өмчийг сайн үйлийн эхлэл гэж хүлээн зөвшөөрөх ёстой¹” гэсэн байдаг.

Өмчлөх эрхийн сэтгэлгээ, түүний онолын үндэс болсон эртний Ромын эрх зүйн сэтгэлгээний хэлбэр ёсоор өмчийн объектыг *res publicae* буюу иргэний гүйлгээнд хамааралгүй эд баялаг, *res privatae* буюу иргэний гүйлгээн дэх эд баялаг хэмээн ангилж байсан бөгөөд *res publicae* нь нийтийн өмч гэсэн ойлголтыг илэрхийлдэг. Ой мод, гол мөрөн, агаар, зам, гүүр гэх зэрэг объектууд нь энэ ангилалд хамаардаг байна². Тухайлбал, Ромын эрх зүйд хувийн өмчийн халдашгүй эрхийг хамгаалж, өмчлөгч хуулиар хориглоогүй бүхнийг хийх эрхтэй байсан бөгөөд өмчлөгчийн эрх гагцхүү бусдын эрхийг зөрчсөн тохиолдолд буюу бусдын эрхийг хамгаалах үүднээс хязгаарлагддаг негатив болон позитив хязгаарлалт хэрэглэгдэж байжээ.

Дундад зууны болон сэргэн мандалтын үеийн европын өмчлөх эрхийн харилцаа үл хөдлөх эд хөрөнгө болоод газар зэрэг бодит объект дээр төвлөрөн хөгжиж байв. Энэ үед худалдааны өсөлтийг нэмэгдүүлэх, мөнгө хүүлэх гэх мэт хуулиар хориглогдсон ашиг сонирхол бүхий гэмт хэргүүдийг таслан зогсоох, мөн төвлөрсөн эзэн хаант улсуудын хөгжил цэцэглэлтийг өндөр түвшинд хүргэх үндсэн зорилтод нийт Европ даяараа анхаарлаа хандуулж байсан нь өмчлөх эрхийн сэтгэлгээг харьцангуй бодитой нөхцөл байдалд хандуулах болжээ.

Т.Хоббс Ж.Локк, Л.Штейн, И.Кант нар хүмүүс үйл ажиллагаа явуулахдаа шаарддаг, хэрэглэж болохуйц зүйлсийг өмчийн хэлбэрээр ашиглаж болно хэмээн иргэдийг Үндсэн хуульд нэгдэхийг шаарддаг ба Үндсэн хуулиар бүгдэд шударга, эрх тэгш хандах үндсэн дээр хэн, юуны өмчлөгч болохыг бодитой тогтоох ёстой гэж үзэж байжээ.

Харин Ф.Гегелийн хүний эрхийн үндэс нь эрх чөлөө бөгөөд энэ нь юуны өмнө хувьдаа өмчтэй байх эрхээр илэрдэг. Аливаа хүн чөлөөт хүсэл зоригтой субъект болохын хувьдаа өмчтэй байх эрхтэй. Хувийн өмчийг өмчлөх

¹ Aristotle (1999), *Nicomachean Ethics* [c. 370 BCE], Terry Irwin (trans.), Indianapolis: Hackett Publishing. Chapter IX Para 8.

² Сэлэнгэ.Х Ромын эрх зүй . УБ.1999 он. 25 дах тал.

эрх тэгш боловч өмчийн хэмжээ нь янз бүр байдаг. Учир нь өмчийн хэмжээ нь тухайн хүний хөдөлмөрөөс шалтгаална. Хувийн өмчид л бие хүний эрх чөлөө илэрнэ гэжээ. 1800-аад оны Европын аж үйлдвэржилтийн хувьсгалын үед А.Смит болон Д.Рикардо нарын хөдөлмөрийн үнэлэмжийн онол нь өмчлөх эрхийн сэтгэлгээнд томоохон өөрчлөлт авчирч, үүний үр нөлөөгөөр өмч нь философийн асуудал гэхээсээ илүүтэй улс төртэй холбон үзэх болсон байна. Францын философич Ф.Бастия (1801-1850) нь өмчийн талаарх үндсэн номлолуудаа “Эдийн засгийн зохицолдоо” өмч бол бодит биежсэн объект биш, харин хүмүүс болон тэрхүү объектын хоорондын харилцаа бол өмч юм гэж үзэж байлаа. Хувийн өмч бол хууль тогтоосны үндсэн дээр үүсдэг бус, харин хувийн өмчийг хамгаалж, түүнийг бэхжүүлэхийн тулд хүмүүс хуулийг бүтээсэн гэсэн үзэл санаагаа илэрхийлжээ.

Ийнхүү өмч болон өмчлөх эрхийн талаарх эрдэмтэн мэргэдийн үзэл баримтлалуудын нийтлэг нь “Эдийн баялагийг тодорхой этгээдэд хамааруулж, уг этгээдэд тухайн баялгийн хувьд олгогдсон хязгааргүй эрхийг бусад этгээд хүлээн зөвшөөрч байгаагаар илэрдэг нийгмийн харилцаа” гэдэг дээр нэгдэж байна.

Амьдрах эрх нь бүхий л эрхийн үндсэн суурь бөгөөд үүнийг хэрэгжүүлэгч нь өмчийн эрх юм. Өмчийн эрхгүйгээр, бусад эрх оршин байж чадахгүй. Өмч гэдэг нь *нийгмийн харилцаа бөгөөд өөртөө материаллаг болон хүсэл зоригийн шинжийг агуулж байдаг*¹. Мөн өмч нь хөгжлийн эхлэл, аливаа зөрчилт зүйлийн үндэс болж байв.

Өмч нь эдийн засгийн агуулгаараа үйлдвэрлэх хүчний элемент, материаллаг зүйл бус, мөн үйлдвэрлэлийн харилцааны тусгаар бүрэлдэхүүн хэсэг биш харин үйлдвэрлэх хүчний элементүүдийн (ажиллах хүч, үйлдвэрийн хэрэгслийн) холбогдох арга буюу бүтэц, үйлдвэрлэлийн харилцааны агуулга, мөн чанар юм².

Баялаг болгон өмч байдаггүй ч өмч болгон баялаг байдаг. Уг баялгийн эзэн нь хүн бөгөөд нийгмийн гишүүдийн хоорондын харилцаа, санаа зорилгод өртөгдөж, тэдний хэрэгцээ, шаардлагыг хангах чанарын агуулгатай болсон нь өмч юм³. Өөрөөр хэлбэл нийгэм дэх материаллаг баялгийг олж авах хэлбэр юм⁴.

Джон Локк “Өмч бол хүнд байгаа бүх зүйл, тухайлбал хөрөнгө төдийгүй, амь нас, эрүүл мэнд, алдар хүнд, хүндэтгэл хүлээх гэх мэт

¹ Гражданское право, под ред. А.П.Сергеева и Ю.К.Толстого. В 3-х частях. М., 1996, 2001, Ч.

1. 323 стр

² Проблемы социалистической собственности, ред. М.Н.Перфильев, М. 1973, 19 стр

³ Цэрэнжээ.Ц, Өмчийн эрх зүй, Уб., 2000, 3 дахь тал

⁴ Оюунчимэг.Б, Олон улсын иргэний эрх зүй, Уб., 2000, 50 дахь тал

хуульчлагдсан эрхүүд юм” мөн "Байгалийн хуулийн дагуу хүн бүр хувийн өмчөө хамгаалах, хүн бүр өмчтэй байх нь түүний ердийн эрх юм¹,

Марксийн үзлээр өмч гэдэг бол тодорхой хүмүүс өөрийн болон эзэмшилдээ байгаа материал баялагтай харьцаж буй харьцаа өмч гээд тэрээр өмчийн хамгаалалт сайтай газар ядуурал байхгүй², өмч нь нийгмийн амьдралд тэр дотроо цехийн байгуулал, гар урлалын хувьд тосгоны жижиг үйлдвэрлэл хэрхэн тушаа, дөнгө болж байсанчлан аж үйлдвэрийн төрүүлсэн нэгдмэл том үйлдвэрлэл, хүчний хувьд хувийн өмч нь мөн тийм тушаа дөнгө болсон юм³, өмч нь зөвхөн нийтийн байх ёстой гэж тайлбарлаж ирсэн байна.

Дээрхээс гадна өмчийн талаар шинжлэх ухааны тайлбар толиудад томъёолсныг тоймлон авч үзвэл: Хүний өмч хэдий чинээ ихсэх тусам түүнд эрх чөлөө төдий чинээ нэмэгдэнэ⁴, “үйлдвэрлэл, хуваарилалт, солилцооны явцад үйлдвэрлэлийн арга, хэрэглээний хэлбэрийг тодорхойлох түүхийн явцад өөрчлөгдөх хүмүүсийн хоорондын бодит харилцааны тогтолцоо”, “иргэн, ба хуулийн этгээдийн мэдэлд байгаа өмчийн эрх, үүргийн нийлбэр цогц”, “эд юмс, эд хөрөнгө”⁵, “ямар нэгэн этгээдэд ногдсон зүйл, хувийн хөрөнгө”⁶, “аливаа этгээдэд байж болох, үнэлж болох эд зүйл”⁷, “үйлдвэрлэлийн хэрэгсэл ба хэрэглээний зүйлс олж авахаар тодорхойлогдох үйлдвэрлэл, хуваарилалт, солилцоо, хэрэглээний хүмүүсийн об’ектив түүхэн өөрчлөгдөх харилцааны эдийн засгийн ухагдахуун, этгээд болох хувь хүн, хамт олонд тодорхой нөхцөл, хэлбэрээр эд хөрөнгө хамаарахыг илэрхийлсэн хууль зүйн ухагдахуун”⁸, “нийгмийн үйлдвэрлэл явуулж, материал баялагийг ашиглах, эзэмших, захиран зарцуулахад чиглэгдсэн хүмүүсийн хоорондын харилцаа”⁹ гэх зэргээр тодорхойлсон байна.

Өмч гэдэг нэр томъёог олон утгаар хэрэглэдэг. Заримдаа эд хөрөнгө буюу эд юмс гэж үздэг. Гэхдээ түүнийг тодорхой нэг эд юмс, эд хөрөнгөтэй бүрэн адилтгаж болохгүй. Учир нь эдгээрийн илэрч буй хэлбэр талаас нь өмч гэж үзэж болох чиг ухагдахууны цаад мөн чанарыг бүрэн дүүрэн ойлгоход учир дутагдалтай.

Өмчийн эрх, түүний эх сурвалжийн талаар олон үзэл баримтлал, урсгал чиглэлүүд түүхэн явцад бүрэлдэн тогтсон хэдий боловч тэдгээрийг нэгтгэн үндсэн 2 бүлэгт ангилж болно.

¹ Эрх зүйн гүн ухаан, орч, В.С.Нерсисянц, Уб., 1999, 151 дэх тал

² Капитал, орч, К.Маркс, 1 дүгээр боть, Уб., 1999, 698 дахь тал

³ Чулуунжав.Л, Өмч, үйлдвэрлэлийн харилцааны хөгжил, төгөлдөржилт, Уб., 1980, 27 дах тал

⁴ Одонхүү.Т, Эрх зүйн философи, Уб., 1999, 53 дахь тал


⁵ Тунгалаг.Д, Эдийн засгийн аюулгүй байдлын тайлбар толь, Уб., 2005, 97-98 дахь тал

⁶Цэвэл.Я, Монгол хэлний товч тайлбар толь, Уб., 1966, 2013, <https://toli.query.mn/>

⁷ <https://www.slideshare.net/KhongorBukhtsooj/ss-69980433>

⁸ Нарангэрэл, С. “Өмч”-ийн тайлбар. Эрх зүйн эх толь бичиг, Уб., (2008)349

⁹ Совд.Г, Монгол Улсын Үндсэн хууль /Хүний эрх/, Уб., 1999, 154 дахь тал



Өмч, өмчийн харилцаа нь эдийн засгийн ухааны үүднээс дараах байдлаар ойлгогддог¹.

- Тодорхой төрлийн эд хөрөнгийн хувьд үүсэж буй хүмүүсийн хоорондын харилцааны нэг хэсэг;
- Эзэмшиж буй хөрөнгөдөө минийх гэсэн ёсоор хандах өмчлөлд үүсэж байгаа харилцаа.

Эрх зүйн дээрх харилцааг хууль зүйн үүднээс дүгнэвэл эд хөрөнгийн талаар үүсч буй хүмүүс хоорондын харилцаа нь эрх зүйн хэлбэрт орсноор эд хөрөнгөө бусад хууль бус халдлагаас хамгаалах боломжийг өмчлөгч этгээдэд олгодог төдийгүй түүнд өмчлөлийн зүйлээ ашиглах хүрээ хязгаарыг тогтоон өгөх замаар өмчлөлийн зүйлдээ харьцах харьцааг нь мөн тодорхойлж өгдөг гэж хэлж болно.

Дүгнэлт

Эдгээрээс дүгнэвэл Эртний Ромын эхэн үеийн заншлын болон эрх зүйн эх сурвалжуудад Гэр бүл нь хүмүүсийн эд хөрөнгийн ашиг сонирхлын нийлбэр цогц, сонгодог эрх зүйн хөгжлийн үед тухайн өрхийн тэргүүний засаглалд багтаж нэгэн гэрийн дотор хамтран аж төрж буй нөхөр, эхнэр, хүү, охин, ач нарын хамааралт холбооны цогц орчин, Ромын Бүгд Найрамдах Улсын хожуу үед гэр бүлд эцгийн монополь эрхийг хязгаарлаж эхнэр хүн зохих хэмжээний эд хөрөнгөтэй байх онцлогийг тусгасан талаар хуульчдын номлол, үзэл баримтлалд дурдсан байна.

¹ Цэдэндагва.Г, Эдийн засгийн ухаан, Уб., 2013

Ромын гэр бүлийн эрх зүй бол өрх гэр, ам бүл гэдэг ойлголтын хууль зүйн мөн чанарыг нээн илрүүлэхэд чухал ойлголтуудыг бий болгосон.

Эртний Ромд үүссэн гэр бүл нь анх омог дотроо гэрлэх цаашлаад өөр омгийн хүмүүстэй гэр бүл болох, Ромын анхны хаант улс бий болсон үеэс гэр бүл нь нэг нөхөр, нэг эхнэртэй байх ёсонд үндэслэн хөгжсөн.

Гэрлэлт нь нийгмийн аль ч үед гэр бүл болсны баталгаа болж байсан бөгөөд одоо ч байсаар байна. Эртний Ромын хуульчид гэрлэлтийн харилцаанд эхнэр, нөхрийн өмчийн талаар нарийн тусгасан нь гэр бүлийн дундын эд хөрөнгийн эрх зүйн суурийг тавьсан юм.

Гэр бүлийн дундын эд хөрөнгө нь хувь хүний оршихуйд нөлөөлдөг хүчин зүйлсийг өөртөө агуулж байдаг тул түүнийг эрх зүйн нийцэлтэй хууль тогтоомжоор хамгаалах нь чухал. Ингэснээр түүний эрхийг хүлээн зөвшөөрөх зорилготой. Энэ нь өмчийн халдашгүй эрхийг хангах суурь үзлийг бэхжүүлэхэд оршино.

Эх сурвалжийн жагсаалт

1. Нарангэрэл, С. “Өмч”-ийн тайлбар. Эрх зүйн эх толь бичиг, Уб., (2008).349
2. Совд.Г, Монгол Улсын Үндсэн хууль /Хүний эрх/, Уб., 1999,
3. Цэдэндагва.Г, Эдийн засгийн ухаан, Уб., 2013
4. Проблемы социалистической собственности, ред, М.Н.Перфильев, М. 1973, 19 стр
5. ¹ Цэрэнжээ.Ц, Өмчийн эрх зүй, Уб., 2000, 3 дахь тал
6. ¹ Оюунчимэг.Б, Олон улсын иргэний эрх зүй, Уб., 2000, 50 дахь тал
7. ¹ Эрх зүйн гүн ухаан, орч, В.С.Нерсисянц, Уб., 1999, 151 дэх тал гм..